

## **БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН 2022 ОНЫ 3 ДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

**2022.03.31**

1. Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 2 дугаар сард хийж гүйцэтгэсэн ажлын тайланг БШУЯамд хүргүүлсэн.
2. ЕБС болон цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн цахим системийн талаар хоёр өдрийн онлайн сургалтыг зохион байгуулсан.
3. Олон улсын эмэгтэйчүүдийн баярын амралтын өдөр байгууллагын аюулгүй байдлыг хангах хариуцлагатай жижүүрийн хуваарь гаргаж ажиллуулсан ба тухайн өдрүүдэд ямар нэгэн зөрчил гараагүй.
4. Аймгийн хэмжээнд сургалт явуулж буй ЕБС-ийн үйл ажиллагаа болон сургалтын чанарыг дээшлүүлэх зорилгоор хамтран ажиллах байгууллагуудын хуваарийг баталсан аймгийн Засаг даргын захирамжийг холбогдох хэлтэс, агентлагуудад хүргүүлж, ЕБ-ын сургуулиудад хэрэгжүүлэх ажлын 10 чиглэлийг байгууллагын дарга нарт гаргаж өгсөн.
5. 03 дугаар сарын 14,15-ны өдрүүдэд зохион байгуулагдах аймгийн удирдах албан тушаалтны зөвлөгөөнд оролцох бэлтгэл ажлаа хангаж, Баян-Өлгий аймгийн БШУГазар 2022 онд хийгдэх гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Аймгийн засаг даргатай хийх гэрээг боловсруулж, ЗДТГ-ын ТЗУХэлтэст хүргүүлсэн.
6. “Хоггүй Цэмцгэр - Өлгий” аяны хүрээнд бүх ЕБС, цэцэрлэг долоо хоног болгон байгууллагын ойр орчмын 50 метр хүртэлх талбайн цэвэрлэгээг тогтмол хийж, харьяа сумын ЗДТГ-т тайланг хүргүүлж байна. Мөн БШУГ хуваарьт газартаа бүрэн бүрэлдэхүүнээрээ цэвэрлэгээ хийсэн.
7. Математик, физик, биологи, хими, газар зүй ба мэдээлэл зүй, түүх, нийгмийн ухаан, орос хэл гэсэн нийт 9 судлахуунаар явагдах төрөлжсөн олимпиадын I давааг сургуулиуд зохион байгуулж байна.
8. Аймгийн хэмжээнд зохион явуулсан монгол хэлний багш нарын ур чадварын уралдаанд ЕБ-ын сургуулиудаас шалгарсан 19 багш оролцож, ЕБ-ын лаборатори 3 дугаар сургуульд 3 өдрийн турш хичээл зааж, мэдлэг, чадвар, заах арга зүйгээ бусад багш нартаа түгээн дэлгэрүүлэх, нэг нэгнийхээ арга зүйгээс суралцсан.

9. Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг, Улсын Их хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.4, 2.5-д заасны дагуу 2021 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин хангалттай үнэлэгдсэн, хугацааны шалгуур хангасан, сахилгын шийтгэл хүлээгээгүй, шаардлага хангасан төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэвийг ахиулан олгох саналыг холбогдох материалуудын хамт аймгийн ЗДТГ-т бичгээр хүргүүлэв.

10. 2022 оны 03 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд “EDUZONE” сургалтын төвтэй хамтарч Эмпати сургуулийг түшиглэн ЭЕШ-ын жишиг сорил зохион байгуулж, дүнг сургуулийн удирдлагуудад танилцуулав. Энэхүү ажлаа 4, 5 дугаар сард дахин зохион байгуулахаар “Амжилтын гараа” төрийн бус байгууллагатай цахим хурал хийлээ.

11. БШУГ-аас ЭЕШ-ын 10 хичээл дээр 2 дахь шалгалтыг авч, материалыг засаж, дүн шинжилгээ хийж, сургуулиудад хүргүүлэв.

12. Аймгийн төвийн 5, 4 дүгээр цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийн үнэт цаасыг бэлэн болгосон.

13. БМДИ-д аймгийн хэмжээний 2 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалтын судалгааг гаргаж хүргүүлсэн.

14. Өлгий сумын баг бүрээс хүүхдийн цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн товч мэдээллийг нэгтгэсэн.

15. Өлгий хотоос гарах, орох 6 чиглэлийн их цэвэрлэгээг 3 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж, ажлын тайлангаа зурагжуулан Өлгий сумын Хот тохижуулах албанд хүргүүлсэн.

16. 2022 оны 03 дугаар сарын 10-ний өдөр Хүүхэд хамгааллын чиглэлээр Цагдаагийн газрын хурлын танхимд Өлгий сумын хувийн болон төрийн өмчийн Ерөнхий боловсролын сургуулийн захирал, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарт хурал хийсэн. Хүүхдүүдийн дунд гарч буй гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, цаашид хамтран ажиллах чиглэлээр төлөвлөгөө боловсруулах талаар санал солилцсон.

17. Аймгийн хэмжээний 9-11 ангийн сурагчдын дунд Физикийн онлайн олимпиад зохион байгуулсан.

18. БШУЯ-ны харьяа БМТТ, Баян-Өлгий аймгийн БШУГ-тай хамтарсан СӨБ, ЕБС-ийн удирдах ажилтнуудын МХХТ-ын ур чадварыг нэмэгдүүлэх зорилго бүхий 3 өдрийн хамтын сургалт амжилттай зохион байгуулагдсан. Энэхүү сургалтад ЕБС, СӨБ-ийн 200-аад удирдах ажилтнууд болон боловсролын газрын мэргэжилтнүүд хамрагдсан.

#### Сургалтын агуулга:

- Medle.mn Ээлжит хичээлийн цахим контентын сан
- Боловсролын салбарын статистик тайлан
- Өдрийн ирц
- Хоол үйлдвэрлэл
- Багшийн цахим журнал зэрэг системүүдийн ашиглалт, хэрэглээ, анхаарах зүйлсийн талаар харилцан ярилцаж, тухайн сургалтын байгууллага дээр эдгээр системүүдийг хөтлөхөд тулгамдаж буй асуудал бэрхшээлийг шийдвэрлэх замаар хамтран суралцсан.

19. Боловсролын мэдээллийн технологийн төвөөс ирсэн мэргэжилтнүүд аймгийн төвийн сургуулиуд, болон Сагсай сумын сургуулиудад ажиллаж сургуулийн интернет сүлжээний өнөөгийн байдал цаашид сүлжээг сайжруулан өргөжүүлэх талаар судалгаа авч ажилласан.

20. Бага сургуулийн захирал, бага ангийн сургалтын менежерүүдэд цахим сургалт зохион байгуулсан.

21. Аймгийн ЕБ-ын сургуулиудын Багшийн хөгжлийн төвийн судалгааг авч нэгтгэж, БШУЯамд хүргүүлсэн.

22. Боловсролын салбарт тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам асуудлын хүрээнд эрдэм шинжилгээний бүтээлээр харилцан туршлага хуваалцах, багшийн судалгаа шинжилгээ хийх чадварыг дэмжих, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд сургуулийн менежментийг хөгжүүлэх туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулагдсан “БАГШ НАРЫН МЭРГЭЖЛИЙН ӨСӨЛТӨД АХМАД БАГШ НАРЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ” эрдэм шинжилгээний хурлын 3-ын даваанд оролцох багш нарын илтгэлийг дахин сайжруулан Боловсролын хүрээлэнд хүргүүлсэн.

23. БШУГ, ГБХЗХГ-тай хамтран эцэг эх, асран хамгаалагчаасаа хол дотуур байранд хүмүүжиж буй хүүхдийг хамгаалах, зөв хүмүүжил төлөвшил олгох ажлыг гардан гүйцэтгэж буй багш, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг явуулж байна.

24. БШУГазрын хамт олон “Хоггүй Цэмцгэр - Өлгий” аяны хүрээнд Цагааннуур чиглэлийн эзэнгүй хогийг цэвэрлэв

25. Аймгийн хэмжээний нийт цэцэрлэгийн багш нар 03 дугаар сарын 16-ны өдөр суралцахуйн чиглэл бүрээр төлөвлөсөн агууллагын хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжихүйц сургалт үйл ажиллагааны арга зүйн санааг бусдад түгээх нэг нэгнээсээ суралцах зорилгоор цэцэрлэгийн нийт багш нарын хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн сургалтын технологийн дагуу сургалтыг зохион байгуулах, сургалтын төлөвлөгөө төлөвлөлтийг агуулга, арга зүйг нэгдмэл байдлаар боловсруулан ирүүлэн, түүний дагуу цахимаар арга зүйн зөвлөгөө өгсөн.
26. “Монгол улсын үндэстний цөөнхийн хүүхдийн хос хэлний сургалтын өнөөгийн байдал, чиг хандлага” цахим хэлэлцүүлэгт БШУГ-ын мэргэжилтнүүд оролцож, мэдээлэл өгсөн.
27. Ховд аймагт зохион байгуулагдсан “Тэгш хамруулах багшийн боловсрол” сургалтад 2 болон 10 дугаар сургуулийн 6 багшийг оролцуулж, Баян-Өлгий аймгийн БШУГазраас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар танилцуулга хийсэн.
28. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор баталсан Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах үеэр байгууллагын ажилтан, албан хаагч нарын мэргэжлийн бүлэг аймгийн мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний сургуулилт, бэлэн байдлын тусгай үйл ажиллагаанд оролцсон.
29. “Наурыз”-ын баярыг зохион байгуулах ажлын комиссоос байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар болон ажлыг биелүүлсэн.
30. 2022 оны 03 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд аймгийн БШУГазрын даргын удирдамжийн дагуу ажлын хэсэг ЕБ-ын лаборатори 2 дугаар сургууль болон Өлгий сумын хүүхдийн 18 дугаар цэцэрлэг, 03 дугаар сарын 9, 10, 11-ний өдрүүдэд Өлгий сумын ЕБ-ын 7 дугаар сургууль болон Өлгий сумын хүүхдийн 2, 4 дүгээр цэцэрлэг, 03 дугаар сарын 16-17-ний өдрүүдэд Өлгий сумын 1 дүгээр сургууль, 03 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд Өлгий сумын ЕБ-ын 9 дүгээр сургууль болон Өлгий сумын хүүхдийн 6 дугаар цэцэрлэг, 03 дугаар сарын 31-ний өдөр Өлгий сумын ЕБ-ын 10 дугаар сургууль болон Өлгий сумын хүүхдийн 21 дүгээр цэцэрлэгүүдэд ажиллаж, удирдах ажилтан, багш нарын бичиг баримттай танилцан хичээлд нь сууж, арга зүйн зөвлөгөө өгсөн.